НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 24 өдөр Дугаар 12/36 Улаанбаатар хот

Хороодын бүтэц, зохион байгуулалтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор өрх, хүн амын тоо, газар нутгийн хэмжээг харгалзан Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт шинээр байгуулах 33 хороог нэгдүгээр хавсралтаар, хороодын хүн амыг тэнцвэржүүлэх зорилгоор Баянзүрх дүүргийн зарим хороодын хүн ам, хилийн цэсийн өөрчлөлтийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай" 8/28 дугаар тогтоолын Баянзүрх дүүрэгтэй холбоотой хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Хороодыг шинээр байгуулах, зохион байгуулалтын өөрчлөлт хийхэд шаардагдах зардлыг 2022 оны төсвөөс санхүүжүүлж, хэрэгжилтийг хангаж зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Ж.БАТБАЯСГАЛАН

1110100077

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн
12/36 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ШИНЭЭР БАЙГУУЛАГДАХ ХОРООДЫН ЖАГСААЛТ

№	Хуваах хороод	Шинээр байгуулагдах хороод
	Нэг. Баянгол дүүрэг	
1	3 дугаар хороо	26 дугаар хороо
2	4 дүгээр хороо	27 дугаар хороо
3	5, 25 дугаар хороо	28 дүгээр хороо
4	20 дугаар хороо	29 дугаар хороо
5	6 дугаар хороо	30 дугаар хороо
6	7 дугаар хороо	31 дугаар хороо
7	8 дугаар хороо	32 дугаар хороо
8	17, 18 дугаар хороо	33 дугаар хороо
9	12 дугаар хороо	34 дүгээр хороо
	Хоёр. Баянзүрх	
10	2, 21, 27 дугаар хороо	29 дүгээр хороо
11	4 дүгээр хороо	30 дугаар хороо
12	5 дугаар хороо	31 дүгээр хороо
		41 дүгээр хороо
13	22 дугаар хороо	32 дугаар хороо
14	20 дугаар хороо	33 дугаар хороо
15	9, 17 дугаар хороо	34 дүгээр хороо
16	23 дугаар хороо	35 дугаар хороо
17	26 дугаар хороо	36 дугаар хороо
18	12 дугаар хороо	37 дугаар хороо
19	8 дугаар хороо	38 дугаар хороо
		39 дүгээр хороо
20	16 дугаар хороо	40 дүгээр хороо
21	14 дүгээр хороо	42 дугаар хороо
22	18, 25 дугаар хороо	43 дугаар хороо
	Гурав. Хан-Уул дүүрэг	
23	11 дүгээр хороо	22 дугаар хороо
24	4 дүгээр хороо	23 дугаар хороо
		24 дүгээр хороо
25	16 дугаар хороо	25 дугаар хороо
	Дөрөв. Чингэлтэй дүүрэг	
26	7 дугаар хороо	20 дугаар хороо
27	12 дугаар хороо	21 дүгээр хороо
28	16 дугаар хороо	22 дугаар хороо
29	17 дугаар хороо	23 дугаар хороо
30	19 дүгээр хороо	24 дүгээр хороо
	Нийт	**33 хороо**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн
12/36 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ХИЛИЙН ЦЭСЭД ӨӨРЧЛӨЛТ ОРОХ ХОРООД

Нэг. Баянзүрх дүүрэг
1 дүгээр хороо
3 дугаар хороо
7 дугаар хороо
10 дугаар хороо
28 дугаар хороо